

# Тусгай зөвшөөрөл олгох

## Тусгай зөвшөөрлийн үйлдлүүд

Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тусгай зөвшөөрлөөр олгосон мэргэжлийн чиглэлийн индексийг бүртгэх, өөрчлөх, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх үйлдлүүдийг удирдана.

### Тусгай зөвшөөрлийн модуль дээр дараах үйлдлүүд хийгдэнэ:

- Тусгай зөвшөөрөл олгох
- Тусгай зөвшөөрөл өөрчлөх
- Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах
- Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх
- Тусгай зөвшөөрөл сэргээх
- Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох

## [Тусгай зөвшөөрөл олгох](#)

Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага болох БШУЯ нь сургалтын байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг бүртгэх юм.

### [Өмнөх нөхцөл](#)

Тусгай зөвшөөрөл олгох үйлдлээс өмнө дараах нөхцөл биелсэн байх шаардлагатай.

#### Үүнд:

- Сургалтын байгууллага үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх

## [Тусгай зөвшөөрөл олгох дараалал](#)


Тусгай зөвшөөрөл олгох үйлдлийг дараах дарааллаар хийнэ.

#### Үүнд:

1. **Тусгай зөвшөөрөл** ерөнхий цэсийг сонгоно.
2. Тусгай зөвшөөрлийн дэд хэсгээс **жагсаалтыг** сонгоно.
3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Тусгай зөвшөөрөл нэмэх** товчийг дарна.
4. Сургалт эрхлэх сургалтын байгууллагыг сонгоно.
5. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.
6. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг хадгалсаны дараа баталгаажуулах товч дарна.

Шинээр тусгай зөвшөөрөл олгох үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Тусгай зөвшөөрөл** ерөнхий цэсийг сонгоно.
2. Тусгай зөвшөөрлийн дэд хэсгээс **жагсаалтыг** сонгоно.
3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **тусгай зөвшөөрөл нэмэх** товчыг дарна



4. Сургалт эрхлэх **сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийг** оруулна.

5. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.

6. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг хадгалсны дараа **баталгаажуулах** товч дарна.

